

МОНГОЛ, ДАНИЙН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

Н.Булган¹

Ю Хуралд оролцож буй та бүхний амрыг эрж мэндчилье. уны өмнө МУИС-ийн ОУЭЗХТ болон Дани Монголын хоёр орны нийгэмлэгүүд хамтран “Дани Монголын харилцаа, түүхэн уламжилал, орчин үе, ирээдүй” сэдэвт энэхүү сонирхолтой онол практикийн өндөр ач холбогдолтой бага хурлыг амжилттай зохион байгуулж байгаад баяр хүргэж амжилт хүсье.

Мөн энэхүү завшааныг тохиолдуулан Монголыг Бээжингээс хамаардаг Данийн Элчин Сайдын Яамнаас энэхүү хуралд өндөр амжилт хүсэж, Данийн ерөнхий сайд, Данийн Худалдаа болон Хөрөнгө оруулалтын Яамны төлөөлөгчид Хятадад маргааш айлчлах учир энэхүү хуралд оролцох боломжгүйгээ илэрхийлснийг уламжилъя.

Данид олон Иргэний нийгмийн байгууллагууд байдаг бөгөөд 4 төрөлд ангилдаг:

- Ашиг сонирхлын байгууллагууд (жишээ нь тахир дутуучуудын байгууллагууд, үйлдвэрчний байгууллагууд, байгаль орчныг хамгаалах байгууллагууд, чөлөөт цагийн холбогдолтой байгууллагууд)
- Шашны байгууллагууд
- Улс үндэстэн хоорондын хамтын ажиллагааны байгууллагууд (найрамдлын, солилцооны, иргэдийн оролцоотой хөдөлгөөнүүд)
- Хөгжлийн болон тусламжийн байгууллагууд

Данийн ИНБ-ын талаарх зарим нэг үзэл баримтлалаас товч танилцуулахад ИНБ-ын зарим нэг онцлог шинж чанаруудаас дурдъя. Үүнд:

- ИНБ нь олон бүлэг, байгууллага, сүлжээний нийлбэр бүтэц бөгөөд нэн тэргүүнд ИНБ нь бүлэг, байгууллага, сүлжээг төлөөлж түүний эрх, ашиг сонирхлыг илэрхийлэх зорилготой учир төр засаг, зах зээл хоорондын орон зайнд оршдог.
- ИНБ төр засаг, нийгэм хоорондын чухал уялдааг бий болгох гүүр боловч төрийн болон ардчиллын байгууллага, институцийг орлож чадахгүй, орлох ч ёсгүй.
- Нийгэм, эдийн засгийн тодорхой үйл явц, хөгжлөөс болж нийгмийн ялгаварлал болон ардчиллын ард иргэд, олон нийтэд хүртэх хүртээмж багсаж улмаар нийгмийн дэг журам алдагдаж, нийгмийн бүлгүүд хоорондын тэмцэл хурцдаж авторитар дэглэм буцаж бий болох өндөр магадлал үүсдэг. Ийм учраас ИНБ-ын байр суурийг өндөржүүлж, түүнийг дэмжиж хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай.

¹ ДМН-ийн тэргүүлэгч гишүүн, Данидагийн шугамаар Монголд хэрэгжүүлдэг буй төслийн зохицуулагч

Монгол, Данийн ИНБ-ын хамтын ажиллагаа, иргэд хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 1920-иод оноос эхлэж байсан нь тухайн үедээ орон нутгийн ард иргэдэд Данийн соёлтой танилцуулаад зогсоогүй орчин үеийн эмчилгээ, ногоо тариалан болон фермийн аж ахуйтай танилцаж сурах боломжийг нээж өгч байсан түүхтэй.

Энэ цагаас хойш ардчилсан хувьсгал Монголд ялж нийгэмд өөрчлөлт шинчлэлтийн үйл явц хүчтэй өрнөж эхэлсэн 1990 онд Данийн Копенхаген хотноо Дани Монголын Нийгэмлэг байгуулагдаж, улмаар тэр ондоо Монголд Монгол Данийн Нийгэмлэг байгуулагдсан нь 2 орны ард иргэд хоорондын найрамдал хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд ихээхэн үүрэг роль гүйцэтгэж эхэлсэн.

Энэхүү үйл явц нь улмаар 2 орны хөгжлийн болон тусламжийн байгууллага хоорондын, мөн ашиг сонирхлын байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг бий болгох тухайн цагийн анхны гараа нь болсон гэж хэлэхэд илүүдэхгүй.

90 оны сүүлч үеээс эхлэн Монгол, Данийн олон иргэний нийгмийн байгууллагууд хамтын ажиллагаагаа эхлэсэн. Үүний дотор Хүүхдийн төлөө үндэсний төв, Монгол-Данийн болон Дани-Монголын Нийгэмлэгүүдийн хамтын ажиллагаа, 2 орны Скаутын байгууллагуудын хамтын ажиллагаа, Монгол, Данийн Боловсролыг дэмждэг төрийн бус байгууллагууд, Хараагүйчүүдийн нийгэмлэгүүдийн хамтын ажиллагаа гэх зэргийг дурьдаж болох юм.

Нийгмийн түншлэлийн сүлжээ (НТС) Монгол талдаа, ДМН Дани талдаа үйл ажиллагаагаа эхлээд өдгөө 15 жил болж байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд олон төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

1997-2007 онд Дани-Монголын сургалтын төвийн хүрээнд 73 хараа хяналтгүй хүүхдүүд, 55 ядуу гэр бүлийн 351 гишүүдийг нийгэмшүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх үйл ажиллагаанд хамруулснаас гадна 21 аймаг, 9 дүүргийн 1700 гаруй нийгмийн ажилтныг богино хугацааны сургалтанд хамруулж, тэдний мэргэжлийн түвшинг дээшлүүлсэн. Мөн 2 жилийн эцнээ сургалтанд 70 гаруй нийгмийн ажилтныг хамруулсан. Төслийн үр дүнд 40 гаруй бага насны хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах болсон, 30 гаруй өсвөр насны хүүхдүүд болон залуус ажил хөдөлмөр эрхлэж, нийгэмд зохих байр суурьтай болсон бөгөөд 55 ядуу гэр бүлийн 351 гишүүдийн амьдрал ахуй дээшилсэн.

2007-2012 онд “Нийгмийн Түншлэлийг бэхжүүлэх” нэртэй төслийг хэрэгжүүлсэн. Уг төсөлд орон нутгийн 5 газрын 1200 гэр бүл хамрагдаж өөртөө туслах бүлгийг байгуулж, жижиг бизнесийг дэмжих бичил зээл олгож, хуримтлалтай болгох, бичил бизнес хөгжүүлэх төрөл бүрийн сургалтанд хамруулж тэдний бизнесийг өргөжүүлсэн. Мөн орчноо тохижуулах, байгаль орчноо хамгаалах гэх мэт олон нийтийн идэвхтэй ажлыг орон нутаг тус бүр хийж гүйцэтгэсэн.

Үүний зэрэгцээ иргэдийн оролцоог хангах зорилготой “Нийгмийн түншлэлийн сүлжээ” төрийн бус байгууллагыг байгуулсан.

Энэ байгууллагын хүрээнд орон нутгийн иргэд, засаг захиргаатай хамтарч ажиллаж байна.

2011 онд хийсэн үнэлгээнд дараах үр дүнг тэмдэглэсэн. Үүнд:

- * “Нийгмийн түншлэлийн сүлжээг бэхжүүлэх” төслийн үйл ажиллагаа амжилттай хэрэгжсэн бөгөөд орон нутгийн гишүүд амьдрал ахуйгаа дээшлүүлэх, орчноо

тохижуулах зорилготой хамтын ажиллагааг өрнүүлэх болсон.

- Мөн зээл, хуримтлал, орон нутгийн иргэдийг чадваржуулах үйл ажиллагааг хослуулан явуулсны үндсэн дээр иргэдийн амьдрал тодорхой хэмжээгээр дээшилсэн.
- Жижиг бизнес эрхлэж байгаа гишүүдийн зах зээлийн хүрээ өргөжсөн. Хоршоо, нөхөрлөл бизнес эрхлэж байгаа бүлгүүдийн дунд бий болж эхэлсэн.
- Орон нутагт хөршийн холбоо байгуулагдсан.
- Орон нутагт иргэний нийгмийн байгууллагыг байгуулахад уг төсөл тодорхой хувь нэмэр оруулсан.

Дээрх төслүүдээс гадна орлого багатай, сурч боловсрох авъяастай гэр бүлийн 45 хүүхэд, залуусын сургалтын төлбөрийг буцалтгүй тусламж болон зээлийн хэлбэрээр олгосон.

Анхаарал тавьсанд баярлалаа